

Үнэ №06(39)

1. Үнэ

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ**

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2010 оны 6 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 1.5 хувиар буурч, харин өмнөх оны жилийн эцсийнхээс болон өмнөх оны мөн үеийнхээс тус бүр 11.4 хувиар өссөн дүнтэй байна (Хүснэгт1).

Ерөнхий индекс өмнөх сарынхаас буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 4.0 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.5 хувиар тус тус буурсан байна. Харин тээврийн үйлчилгээний бүлгийн дүн 0.2 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 0.7 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 3.4 хувиар тус тус өсчээ. Согтууруулах ундаа, тамхи болон боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ тогтвортой байв.

Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны 6 дугаар сард өмнөх оны жилийн эцсийнхээс 11.4 хувь өссөний дотор боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой, бусад бүлгийн үнэ 0.9-23.3 хувиар тус тус өсчээ (Хүснэгт1).

Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 11.4 хувь өссөний дотор хүнсний барааны бүлгийн үнэ 14.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 13.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 12.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 11.7 хувь тус тус өссөн нь өндөр өсөлт бөгөөд эдгээрээс бусад бүлгийнх 1.2-9.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1

**Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр**

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	хувь		
		2010 VI 2009 VI	2010 VI 2009 XII	2010 VI 2010 V
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>111.4</b>	<b>111.4</b>	<b>98.5</b>
Хүнсний бараа, ундаа, ус	39.7	114.9	123.3	96.0
Согтууруулах ундаа, тамхи	2.8	102.8	101.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	15.3	111.7	103.7	99.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.8	108.6	103.9	103.4
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.6	107.4	103.8	100.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.8	103.9	101.0	100.5
Тээвэр	9.0	107.9	101.0	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.9	113.8	114.7	100.7
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.0	101.2	100.9	99.5
Боловсролын үйлчилгээ	5.4	109.9	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1.0	112.7	109.2	100.9
Бусад бараа, үйлчилгээ	2.7	107.0	102.1	99.8

ХҮУИ 2009 оны 6 дугаар сард өмнөх оны жилийн эцсийнхээс 4.2 хувиар өсч байсан бол 2010 оны 6 дугаар сард энэ үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 7.2 пунктээр өндөр байна (Зураг 1).

Зураг 1

